

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Эрдэм шинжилгээний бичиг

Боть XLII

Улаанбаатар

2018

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО ХИЙГЭЭД ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ГАРАЛ НЭГТЭЙ ХЭДЭН ХЭЛЦИЙН ТУХАЙ

М.Ууганбаяр

Монголын нууц товчооны 140-р зүйлд *Belgutei darun yadan türüdeju sa'ari de'ere qarču Belgutei qinčas kiju činggis qahan-ni iijegü-lü'e qahan ilügey-iyen ja'uba* (Ligeti, 1971:93), Бэлгүдэй даран ядан мөрдөж саарын дээр гарч Бэлгүдэй хянчасхийж Чингис хааныг узэхүй лүгээ хаан улхийгээ зуув (Чоймаа, 2011:84) гэж гардгаас “улхийгээ зуух” хэмээх хэлцийг орчин цагийн монгол хэлний тохирох хэлцтэй харьцуулах нь сонирхолтой юм.

Энэхүү хэлцийн “илүгэй (ilügei) буюу улхий” хэмээх үгийн тухайд Элдэндай, Ардажав нар Зостын аймгийн Түмэд баруун хошууны аман ярианд доод уруулыг *ilig* “илиг” гэж хэлдэг болохыг мөн буриад хэлнээ үлхы гэх нь “эрүү” гэсэн утгатайг заажээ (Элдэндай, Ардажав, 1986:386). Энд буй “улхийгээ зуув буюу доод уруулаа зуув” гэх хэлцийг Ц.Дамдинсүрэн одоо үеийн монгол хэлнээ хөмхийгөө зуув (1990:88) хэмээн буулгасан нь сонирхолтой бөгөөд Монголын нууц товчооны ”улхийгээ зуух”, орчин цагийн монгол хэлний “хөмхийгөө зуух” гэсэн хэлц нь гарал нэгтэй юм. Орчин цагийн монгол хэлнээ “хөмхийгөө зуух” гэх хэлц дургүйлхэн хорссон байдал гаргах гэсэн утга илэрхийлнэ. Жишээ нь:

Тэгэхдээ атаяа жсөтөө нь хөдөлж хөмхий зуун “Чам шиг муу тэжээсэн голөг надтай узэлцэх болоогүй харж байгаарай. Нуурэн дээр чинь ямар хүн болохоо харуулаад өгнө” гэж шивнэж билээ (Д.Гармаа. Цагаан булаг).

Ийнхүү учир дүрсгүй уурлан багтарсан Бат хөмхий зуун хана тушуулж тавьсан хүрээ авлаа (З.Сандагаа. Хүний ганц)¹ (Аким, 1982:155)

Орчин цагийн монгол хэлнээ “хөмхий зуух” хэмээх хэлцтэй ойролцоо санааг илэрхийлдэг “шазуур зуух, шүд зуух, араагаа зуух буюу араандаа зуух” гэсэн хэлцүүд байна.

“Шазуур зуух” гэх хэлц нь муу санах, занах, тэвчих гэсэн олон утгыг агуулдаг байна. Жишээ нь:

муу санах

Итгэлтэд хоёр бодол төрлөө. Нэгдүгээр нь Эрдэнэтэй түргэн уулзаж, бүх бодсоноо хэлэх, хоёрдугаарт нь тэр хэрэв шазуур зууж данс бодох гэвэл Бадарч мэт тэнэг муцуудыг ашиглан хариу данс бодох ийм хоёр бодол тороод тэр нь цаг онгорөх тусам гарцаагүй зөв зүйл болон бэхжсив (Ч.Лодойдамба. Тунгалаг Тамир).

¹ Уран зохиолын жишээг Г.Аким. Монгол хэлний өвөрмөц хэлцийн товч тайлбар толь (Уб., 1982) бүтээлээс дам авав.

занах

Чи ч их бялдууч амьтан даа бас тэгээд хэзээний их хоосон гоё үгтэйгий чинь яана Намнансурэнг ханы зэрэг залгасан болохоор чи түүнд зулгайдаж, итгэлтэй хүн болох гээд биднийг шүдний чигчлүүр шиг санаж яваа биз гэж Цогтдарь шазуур зуун хэлээд юу болов гэмээр царай нь хувисхийн дусал нулимс унагалаа (Ж.Пүрэв. Аянга).

тэвчих

Буюн нэвт хатгагдсан гуяны шарх руу ногоо талхи хийж цамцаа урж боогоод шазуур зуун босож харвал цагантнууд хүрээний төвд орсон улаан цэрэг монгол цэрэгтэй нударгаар үзэлцэж энд тэндгүй бөх барилдаа ажил алхилдаан болж байгаа үзэгдэнэ (Л.Түдэв. Уулын үер)

“Шүд зуух” хэмээх хэлц тэвчин тэсвэрлэх, занах, хорсон занах муу санах зэрэг утгыг агуулдаг байна. Жишээ нь:

тэвчин тэсвэрлэх

Яс нь яйрч мах нь язарсан мортлою шүд зуусаар байна уу (З.Баттулга. Хөх тэнгэр).

Мань эрийн /Батбаярын/ сэтгэлд бодогдоож байгаа цорын ганц зүйл нь Аюур бойдаа миний нүүрийг дахиж хэзээ ч харахгүй арга мэх хийсэн болоод намайг өөрөөр минь өөрийг шүүхэд хүргүүлж дээ. Би яалаа ч амь хэлтрэхээ өнгөрсөн хүн байж биеэ гүтгэж нэрээ бузарлахгүй юм шүү гэж шүд зуусаар байв (Ж.Пүрэв. Аянга).

занах хорсон занах

Кимура улам шүд зууж азтай мочийг цаг ямагт хүлээсээр байв (Д.Гармаа. Цагаан булаг).

Орчин цагийн монгол хэлнээ “араагаа зуух” буюу “араандаа зуух” хэмээх хэлц нь муу санах, юм санах, хорсол өвөртлөх гэсэн утгатай ажээ. Жишээ нь:

юм санах

Гэхдээ Итгэлт энэ тухайгаа хэнд ч хэлээгүй бөгөөд нүүрэн дээрээ Батад юм санаагүй юм шиг дүр үзүүлэвч цаанаа араагаа зууж элдэвээр хавчдаг болов (Ч.Лодойдамба. Тунгалаг Тамир).

хорсол овортлох

Гэтэл одоо Жамц тэр нэгэн хорсгон бөгөөд далан таваар бууж өгсөн гутамишигаа мартаагүйгээр барахгүй араандаа зууж яваа гэдгийг Донров төдий л сайн санахгүй байна (Л.Чойжилсүрэн. Морин төвөргөөн).

Ийнхүү Монголын нууц товчооны олон хэлцийг гарал үүсэл нэгтэй одоо үеийн хэлцтэй харьцуулан үзэх хэрэгтэй юм.

Номзүй

Аким Г. Монгол хэлний өвөрмөц хэлцийн товч тайлбар толь. Уб., 1982.

Гаадамба Ш. Монголын нууц товчоо монгол аман зохиолд холбогдох асуудалд. Монголын нууц товчооны судлалын зарим асуудал. Уб., 1990.

Дамдинсүрэн Ц. Монголын нууц товчоо. Уб., 1990.

Монголын нууц товчоо. Худам монгол бичгээр монгол бичиг, утга судлалын үүднээс Шанжмиятын Гаадамбын төсөөлөн нягталж сэргээсэн сийрүүлэг эх тайлбар. Уб., 1990.

Пюрбеев Г. Ц. Глагольная фразеология монгольских языков. М., 1972.

Чоймаа Ш. Монголын нууц товчоо. Эртний үг хэллэгийн тайлбартай шинэ хөрвүүлэг. Уб., 2011.

Eldengdei, Ardagab. Mongyul-un niyuča tobčiyan seyiregülül tayilburi. Kökeqota, 1986.

Ligeti L. Histoire Secrete des Mongols. Budapest, 1971.

**On some phraseologisms of the Secret History of the Mongols
and modern Mongolian language of one origin**

In this paper, the author compares one phraseologism from the Secret History of the Mongols with some phraseologisms of modern Mongolian language. According to the author, the phraseologism of *iliügey-iyen ja'uba* ‘to bite one’s lower lip’ has one origin with some modern Mongolian phraseologisms such as *хөмхийгөө зүүх* ‘to set ones jaw’, *шаазур зүүх* ‘to bite one’s lower lip’, *иүүд зүүх* ‘to clench one’s teeth’, *араагаа зүүх*, *араандадаа зүүх* ‘to clench mid molar’.